

“УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛЛЫГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах асуудал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг болон Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын² /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Монгол орны байгаль харьцангуй унаган төрхөө хадгалж үлдсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа, байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, бэлчээрийн зохисгүй хувиар, уул уурхайн салбарын өсөлт, хөрс, агаарын бохирдол зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалж цөлжилт, байгалийн нөөцийн хомсдол, байгаль орчны доройтол эрчимтэй явагдаж байна. Тухайлбал: Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх судалгааны ажлын тайлангаас үзэхэд манай орны нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр цөлжилтөнд өртөж, нийт бэлчээрийн 70 орчим хувь талхлагдаж, 300 гаруй зүйлийн амьтан, ургамал устах аюулд орж олон арван гол, горхи, булаг, шанд, нуур цөөрөм ширгээд байна.

Иймд урьд нь Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан Дархан цаазат газрын талбайн хэмжээг нэмэгдүүлэн байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгон улсын тусгай хамгаалалттай газарт хамруулснаар биологийн олон янз байдлыг хамгаалах, байгаль-экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй их өвийг ирээдүй хойч үедээ дамжуулан үлдээх, орчны доройтлыг хязгаарлан зогсоох, тусгай хамгаалалттай газар нутаг болон Орчны бүсийн ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэднийг хамгааллын менежментийн үйл ажиллагаанд татан оролцуулах, горим дэглэмийг сахин хамгаалах замаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол улс 2024 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 25 хувийг Улсын тусгай хамгаалалтад авах зорилтод дэмжлэг үзүүлнэ.

¹ Төрийн мэдээлэл эмхтгэл. № 25. 2015 он.

² Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасны дагуу дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан тохиолдолд хамгаалалтын захиргааг шинээр байгуулдаг. Булган уулыг Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хариуцуулан шинээр хамгаалалтын захиргаа байгуулахгүйгээр шийдвэрлэх боломжтой.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Орчин үед техник технологийн дэвшил, байгалийн баялгийн ашиглалт, хүн амын өсөлт болон шилжилт хөдөлгөөн зэрэг олон шалтгааны улмаас байгаль орчинд үзүүлж буй хүний үйл ажиллагаатай холбоотой сөрөг хүчин зүйл ихээхэн нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөө улам бүр зогсолтгүй нэмэгдсээр байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийт иргэд	Байгалийн зүй бус ашиглалтаас үүдэлтэй байгалийн бохирдол, байгалийн тэнцэл алдагдлын хор уршигт нийт иргэд өртөнө. Өөрөөр хэлбэл, улс орны аюулгүй байдал, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд төдийгүй эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөөтэй.
2	Орон нутгийн иргэд	Байгальд учирсан хохирлын сөрөг үр дагаварт тухайн орон нутгийн иргэд хамгийн ихээр өртөнө. Энэхүү эрсдэлт байдал нь амьдрах орчин төдийгүй орчны бохирдол, ядуурал, ажилгүйдлээс үүдэлтэй шилжин суурьшилт, уугуул иргэдийн соёл, уламжлалаа алдах зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгоно.
3.	Төр/төрийн албан хаагч	Төрөөс зарим шаардлагатай газар нутгийг тусгай хамгаалалтанд авалгүй орхих нь эргээд тухайн газрыг нөхөн сэргээхэд улсын төсвөөс ихээхэн зардал шаардагдахад хүргэж байна.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас оршин суугаа газрын байгаль орчныг хамгаалах, тэдгээрийг зүй зохистой ашиглахад иргэдийн оролцоо, хяналт хязгаарлагдаж, төр, иргэн, төрийн бус байгууллагуудад давхар зардал үүсгэх, иргэдийн төрд итгэх итгэл алдагдах, хүнд суртал, чирэгдэл, дур зоргоор авирлах байдлыг нэмэгдүүлж болзошгүй байна.

ХОЁР.АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Уул уурхайн салбарын хурдацтай хөгжил, хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, үндэсний хэмжээнд төдийгүй дэлхийн хэмжээнд устах аюулд орсон болон устах аюулд орж болзошгүй олон зүйлийн амьтан, ургамлын үндсэн тархац нутаг, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах,

байгалийг унаган төрөхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээх, ногоон эдийн засгийн хөгжлийн түшиц газрыг бүрдүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгаас үзүүлж байгаа мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, цэвэр усны хангамж зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн голлох салбарт экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдол, эдийн засгийн үнэлэмжийг тодорхойлох, дүйцүүлэн хамгааллын менежментийг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ болон тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь хүргэх зорилгыг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгийг боловсруулах шаардлагатай боллоо.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Ерөнхий зорилго:

Байгалийн бүсийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах, унаган төрөхөө хадгалсан, шинжлэх ухаан хүн төрөлхтний соёл иргэншлийн онцгой ач холбогдолтой, түүх соёл, экологийн боловсрол, хүмүүжил, танин мэдэхүйн ач холбогдолтой, аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газар нутгийг хамгаалах.

Тусгай зорилго:

Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаар байгаль түүхийн үнэт өв тусгай хамгаалалтад орно.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1 Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ. Цаашид тулгамдсан асуудал нэмэгдэх болно.	Үр дүн сөрөг
2 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй ч иргэдийн идэвх, хяналт тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай. Гэхдээ энэ нь асуудлыг сайжруулах нэг хэлбэр болохоос асуудлыг бүрэн шийдвэрлэх хувилбар биш.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
3 Зах зээлийн эдийн засгийн	Тодорхой тохиолдолд татвар хураамжаас	Зардал шаардагдана. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол	Тодорхой үр дүнд

	хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	чөлөөлөх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, урамшуулах нь үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой ч тогтвортой байж чадахгүй.	шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Тусгай хамгаалалттай газар нутгийн азар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлд төрөөс шууд мөнгөн дэмжлэг үзүүлэх нь зарим талаар үйл ажиллагааг дэмжих хэдий ч түр зуурын арга хэмжээ тул зорилгыг хангаж чадахгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Байгаль орчны доройтлыг бууруулах, байгалийн нөөцийн хомсдолыг зогсоох, байгаль, түүх соёлын үнэт зүйлийг өвлүүлэн үлдээх, хамтын менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах хуулиар хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, ажиллах нийтлэг журмыг батлан мөрдүүлэх (Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх) асуудлыг хуулийг хэрэгжүүлэх боломжгүй юм.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Газар нутгийг улсын тусгай хамгаалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах	Зардал бага гарна. Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хариуцуулна.	Үр дүнтэй

**ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ
ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хувилбар 7-ийн хүрээнд тавигдсан Зорилтын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг тооцож үзвэл:

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутагт зарим үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, зэрэг эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.

	хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх			
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлснээр хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Тухайн асуудлыг холбогдох хуулиар буюу Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар зохицуулна.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Тогтоолын зорилго, шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр иргэдийн байгалийн нөөц ашиглах эрхэнд тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	<ul style="list-style-type: none"> • Иргэн • Нутгийн оршин суугч • Хуулийн этгээд • ТББ
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Нутгийн оршин суугчид малчид болон байгалиас шууд хамааралтай ажил хөдөлмөр эрхэлдэг бусад иргэдийг тодорхой нөхцөл шалгуурын дагуу үйл ажиллагаа явуулах боломжтой.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байллыг хангаж	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх			
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр, хуулийн этгээд үүрэг хүлээнэ.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хязгаарлалт бий болгох эсэх			
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар судалгаа шинжилгээ хийх боломж бүрдэнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутаг буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газрын хэмжээ нэмэгдсэнтэй холбогдон хамгаалалтын захиргаанд байгаль хамгаалагчын ажлын байр шинээр нэмэгдэнэ. Мөн иргэн, хуулийн этгээдтэй гэрээний дагуу хамтран ажилласанаар түр болон байнгын ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутаг буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тухайн орон нутагт байгальд ээлтэй жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар болон тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлснээр төрд тодорхой зардлын ачаалал үүсгэх хэдий ч гарах үр дүнтэй харьцуулахад төдийлэн их бус байна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газрын хэмжээ нэмэгдсэнтэй холбогдон хамгаалалтын захиргаанд байгаль хамгаалагчын ажлын байр шинээр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд	Тийм	Үгүй	Орон нутгийн иргэд, малчид, байгалийн үр шимийг шууд хүртэгчдэд эерэг нөлөө үзүүлнэ.

	нөлөө үзүүлэх эсэх			
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн төрийн зүгээс тавих хяналт сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө

	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус болон мэргэжлийн байгууллагад хариуцуулан хамгаалуулах эрх зүйн орчин бүрдсэнээр төрийн ачаалал багасч, байгаль хамгаалалд төр хувийн хэвшлийн хамтын түншлэл бий болно.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрахад эерэг нөлөө гарна.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх явц сайжирч, эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн нөлөө илрүүлэлтэд үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Түүх, соёлын үнэт өвийг хамгаалах, түүнд тавих хяналтыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн оролцоо, санаачлагыг нэмэгдүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулах эерэг нөлөөтэй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	эсэх			
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Амьтан, ургамал зэрэг байгалийн тэнцвэрт байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ховордсон амьтан, ургамлыг нутагшуулах, зориудаар өсгөн үржүүлэх, ховордсон ургамлыг тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах боломжтой байна.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хамгаалалтыг сайжруулах эерэг нөлөөтэй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тогтоолын төсөл бүхэлдээ тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн тул эерэг нөлөөтэй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хамгаалалтыг сайжруулах эерэг нөлөөтэй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн эерэг нөлөө үзүүлнэ.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хөрсийг нөхөн сэргээх, хамгаалахад чиглэсэн бөгөөд түүнийг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглож, хязгаарласан газар нутгийн хэмжээ нэмэгдэж эерэг нөлөө үзүүлнэ.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ашиглалт, хамгаалалтыг нэмэгдүүлнэ.

	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Ашиглалт, хамгаалалтыг нэмэгдүүлнэ.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ашиглалт, хамгаалалтыг нэмэгдүүлнэ.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ашиглалт, хамгаалалтад иргэд, төр аль аль нь зэрэгцээ хяналт тавих боломж нэмэгдэж, үр ашиг сайжирна.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Олон улсын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд газар нутгийг тусгай хамгаалалтад авах нь дэлхий нийтийн хэмжээнд байгаль орчны доройтлыг хязгаарлан зогсоож, байгалийн жам ёсны шүтэлцээг хангах сонгодог хэлбэр бөгөөд хүн төрөлхтний байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэх чухал арга гэдгийг НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн тунхаглал”, “Дэлхийн тунхаглал”, “Тогтвортой хөгжлийн XXI зууны үйл ажиллагааны хөтөлбөр” /НҮБ/, Байгаль орчин ба хөгжил” дэлхийн бага хурал. Рио-де Жанеро /1992/, Тогтвортой хөгжлийн талаарх Йоханнесбургийн тунхаглал, Йоханнесбург/2002/ зэрэг баримт бичигт хэмээн тодорхойлжээ.

- **Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалын талаархи олон улсын жишиг:**

Дэлхий дахинд экологийн тэнцлийг хангах, биологийн төрөл зүйлийн хомсдолыг хязгаарлан зогсоох, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тусгай хамгаалалттай газар нутаг чухал үүрэг гүйцэтгэдэг, даяаршсан шинж чанартай томоохон салбар боллоо. Олон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ өргөжиж, улам бүр тэлсээр байна.

Манай улс дэлхийн хөгжлийн энэхүү чиг хандлагыг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийнхаа сүлжээг өргөжүүлэн, хамгаалалт менежментийг дэлхийн жишигт хүргэх нь төрөөс экологийн талаар баримтлах бодлогын чухал зорилт болж байна. Олон улсын хэмжээнд /2010 оны байдлаар / 19.4 сая ам. дөрвөлжин. км талбай бүхий 114296 газрыг тусгай хамгаалалтад авч, түүний талбайн хэмжээ дэлхийн нийт газар нутгийн 12.9 хувийг эзлэх болжээ. Үүнээс дархан цаазат газар 5549, үндэсний парк 4022, байгалийн дурсгалт газар 19813, байгалийн нөөц газар 27466, хамгаалалттай байгалийн үзэсгэлэнт газар 8495, нөөцийг зохицуулалттай ашиглах

Тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх талбайн хэмжээг ангилал тус бүрээр авч үзэхэд үндэсний парк болон нөөцийг зохицуулалттай ашиглах газрууд хамгийн их талбайг эзэлнэ. Хойд Африк, Ойрхи Дорнодын орнуудын нийт нутаг дэвсгэрийн 10.02%, Европын орнуудын 16.72%, Антарктидийн 0.50%, Номхон далайн орнуудын 11.95%, Карибийн тэнгисийн орнуудын 29.05%, Хойд Америкийн орнуудын 17.31%, Австрали, Шинэ Зеландийн 19.19%, Зүүн өмнөд Азийн орнуудын 18.60%, өмнөд Азийн 6.91%, Зүүн Азийн 15.0%, өмнөд Америкийн 22.55%, Төв Америкийн 30.28% тус тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ. Зүүн Азийн орнуудын хэмжээнд 6 ангиллаар 3267 газрыг тусгай хамгаалалтад хамруулсан байна. Манай хөрш орнуудын хувьд ОХУ 6 ангиллаар, БНХАУ 10 ангиллаар газар нутгийг тусгай хамгаалалтад авч байна.

Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн статусыг 1940 онд Вашингтоны конвенциос анх томъёолон гаргажээ. Дэлхийн улс орнуудад хамгаалалттай нутаг дэвсгэрийн олон янзын ангилал хэрэглэгддэг бөгөөд эдгээр ангиллуудыг үндэслэн 1978 онд Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооноос (IUCN, 1978) хамгийн түгээмэл, тодорхой үйл ажиллагаа явуулдаг 10 ялгавартай ангиллыг олон улсын хэмжээнд хэрэглэж болох юм хэмээн үзээд албан ёсны ангилал болгосон байна. Энэхүү ангиллаар:

- 1/дархан цаазат газар;
- 2/байгалийн цогцолборт газар;
- 3/дурсгалт газар;
- 4/зохицуулалттай байгалийн нөөц газар;
- 5/хамгаалалттай ландшафт;
- 6/байгалийн нөөц газар;
- 7/антропологийн нөөц газар;
- 8/байгалийн иж бүрдлийг хамгаалах нөөц газар;
- 9/шим мандлын дархан газар;
- 10/дэлхийн өвд орох газар гэсэн ялгавруудыг тогтоосон.

Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооноос олон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн жагсаалтыг гаргахдаа дээр дурьдсан бүх газруудыг нэгтгэж байсан.

Харин сүүлийн үед Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо, ДБХС, Мониторингийн төвөөс хамтран боловсруулсан тусгай хамгаалалттай газар нутгийн дараахь шинэ ангиллыг олон улсын түвшинд мөрдөх болсон:

- 1/дархан цаазат газар;
- 2/байгалийн цогцолборт газар;
- 3/байгалийн дурсгалт газар;
- 4/биологийн төрөл зүйл, амьдрах орчныг хамгаалах газар;
- 5/хамгаалалттай ландшафт;
- 6/нөөц газар гэсэн 6 ялгавартай ангиллыг тогтоожээ.

Энэ ангиллын дархан цаазтай газар нь дотроо дархан цаазат газар (1а), онгон зэлүүд газар (1б) гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Хамгаалалттай газруудын ангиллыг нэрээр нь бус I, II, III гэх мэт дугаараар нь тэмдэглэх явдал (ШСТЧ, 1998) түгээмэл болжээ. Энэ

ангилалд багтах газрууд нь үүрэг зорилго, хамгаалалтын горимын хувьд хоорондоо ялгаатай байдаг.

Эндээс дүгнэхэд дэлхийн улс орнууд эдгээр ангиллаас өөр өөрийн орны онцлогт тохирсон ангиллуудыг авч хэрэглэдэг байна. Харин манай улсын тусгай хамгаалалтын ангилал, тогтолцоо дээрх олон улсын жишиг болон олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцэж байгаа болно.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах, ногоон хөгжлийн түшиц газрыг бий болгоход экологийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьсан менежмент бүхий тогтолцоог бэхжүүлэн хамгаалах, түүндээ зохицсон уламжлалт мал аж ахуйгаа хүн төрөлхтний соёл иргэншлийн нийтлэг ололтоор баяжуулан хөгжүүлэх үүднээс Монгол Улсын зарим газар нутгийг шинээр болон урьд батлагдсан хамгаалалтын талбайн хэмжээг өргөтгөн Улсын тусгай хамгаалалтад хамруулснаар дараах үр дүн гарна гэж **Дүгнэж** байна. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт газар нутгийн 25 хувьд хүргэх зорилгод нэмэр болно;
- Биологийн олон төрөл зүйлийн хомсдолыг хязгаарлан зогсоох, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ;
- Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажилд иргэд, хуулийн этгээд оролцох, санал, санаачилгаа төрийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх, үр шимийг нь хүртэх боломж нэмэгдэнэ;
- Тусгай хамгаалалттай газар нутаг түүний орчны бүсэд олон нийтийн хяналт тогтолцоо бүрдэнэ;
- Нутгийн уугуул, ялангуяа уламжлалт аргаар аж ахуй эрхэлдэг иргэдийн зохион байгуулалт сайжирч, нутгийн бэлчээр, байгалийн баялгийг зөв зохистой ашигладаг болно;
- Ажлын байр, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх зэргээр орон нутгийн иргэдийн амьжиргаа дээшилж, улмаар хэт төвлөрлийг сааруулна.

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааны үр дүнд үндэслэн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, холбогдох бүрдүүлбэрийг ханган зохих журмын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.